

Төрөхөөр өвдөж эхэлсэн бол хэзээ эмнэлэг дээр ирэх вэ When to Come to Hospital in Labour

Mongolian

September 2018

Та хүүхдээ төрүүлэхээр эмнэлэгт ирэхийнхээ өмнө өөрийн төрөх тасаг эсвэл эх баригчтайгаа холбоо бариарай. Эх баригч танд юу хийхийг хэлж өгөх ба таны асуултуудад хариу өгөх болно.

Хэрэв та анхныхаа хүүхдийг төрүүлэх гэж байгаа бол

Хэрэв та төрөх дөхсөн бөгөөд /37 долоо хоног буюу түүнээс дээш жирэмсэн/ та доорх ннөхцөл байдал үүссэн бол эмнэлэгт ирэх хэрэгтэй

- Таны төрөх өвдөлт ойр ойрхон хүчтэй болж, нэг удаагийн өвдөлт эхлэхээсээ дуустал 60 секунд болж байгаа бол. Базалт нь ийм маягаар хамгийн багадаа 1 цагийн хугацаатай үргэлжилнэ. Төрөх өвдөлт нь ихэнх эмэгтэйчүүдэд 3-5 минутын зайтайгаар ирдэг.

ЭСВЭЛ

- Таны ус хагарах. Энэ нь хүүхдийн эргэн тойрон байгаа ус хагарч байгаа гэсэн үг юм. Танд бага зэргийн ус гарах эсвэл гэнэт нойтон оргиж шингэн зүйл гарах маягаар мэдрэгдэнэ. Эх баригч гарч буй усны өнгө, үнэрийг таныг эмнэлэгт ирэхэд тань шалгана.

ЭСВЭЛ

- Тод улаан өнгөтөйгөөр цус алдах

Хэрэв та анхныхаа хүүхдийг төрүүлэх гэж байгаа бөгөөд 37-гоос бага долоо хоногтой байхад тань төрөлтийн өвдөлт мэдрэгдэх, ус хагарах юм уу цус алдвал эмнэлэгтэйгээ холбогдоорой.

Хэрэв та урд нь төрж байсан бол

Та дээрх зөвлөмжийг дагах бөгөөд базалт нь хоорондоо 5-7 минутын зайтай болбол эмнэлэг дээр ирээрэй.

Хэрэв танд англи хэлээр ойлголцоход тусламж хэрэгтэй бол?

Англи хэлээр ойлголцоход тусламж хэрэгтэй байгаа бол мэргэжлийн орчуулагчийн үйлчилгээг авч болно. Танд хэдийгээр энэ тал дээр туслах найз нөхөд хаамтан байсан ч гэсэн эмнэлгийн зөвөлгөөг мэргэжлийн орчуулагчийн тусламжтайгаар хийх ёстой байдаг. **Орчуулгын үйлчилгээ үнэгүй бөгөөд мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй байдаг.**

Танд орчуулагч гаргаж өгөөгүй бол та орчуулагч хүсэх эрхтэй бөгөөд эмнэлгийн ажилчид танд орчуулагч захиж болно.

Орчуулагч хэрэгтэй бол 131 450 дугаараар Орчуулгын алба (TIS)-тай холбогдоорой.

Холбоо барих утас

Нэр: _____ Утас: _____